

ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагчийн нэр: [Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын Тамгын газар]
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалтын нэр: [Үндэсний бөхийн дэвжээ худалдан авах]
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: [БХАЖИСЗДТГ/20260202006]
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: [багцгүй.]
ТШЗ 1.4.	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бичих: Байхгүй.
ТШЗ 1.5	Тендер шалгаруулалтын урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: [үгүй]
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр: [Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт]
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 40,000,000/Дөчин сая/ төгрөг
Б.АГУУЛГА	
ТШЗ 10.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: [Үнэлгээний хорооны нарийн бичиг Б.Хашчулуун] Хаяг: [Жинст сумын ЗДТГ-ийн 2-р давхар 205 тоот] Утасны дугаар: [88041265 96118873] Цахим шуудангийн хаяг: [khashchuluunhashaa@gmail.com]
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: [Үгүй]
В.ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэлийг ТШЗ 12.1-д зааснаас өөрөөр заах бол: [Монгол хэл]
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: [зөвшөөрөхгүй]
ТШЗ 16.2	Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг шаардах эсэх: [Тийм]
ТШЗ 17.2.	Техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлоход шаардах баримт бичиг: [Шаардана] ➤ Тендерт оролцогч 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний Ерөнхий болон тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ. ➤ Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар дэлгэрэнгүй танилцуулга, хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ. / 3 дугаар бүлгээс маягтыг харах/ ➤ Нийлүүлэх бараа нь захиалагчийн гаргасан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангаж байгааг нотолсон мэдээллийг баталгаажуулан ирүүлнэ. ➤ Барааны үнийн задаргаа /5 дугаар бүлэг-Маягт 2/ болон бараа нийлүүлэх хуваарь /3 дугаар бүлгээс маягтыг харах/-г батлагдсан маягтын дагуу гарган тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтны тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулан ирүүлнэ. ➤ Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд тендерт ирүүлсэн гэрээний үнэ, хугацаанд багтаан техникийн тодорхойлолтын дагуу заасан цэгт хүргэж, хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж

	ирүүлнэ. ➤ Ижил төстэй ажлыг захиалагч байгууллагаас тодруулахад татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлэх ➤ Барааны үнийн задаргаа нийлүүлэлтийн хуваарьт нийлүүлэх барааны нэр, гарал үүсэл, загварыг тодорхой бичиж ирүүлэх. Тухайн барааг эцсийн цэгт хүргэж өгөх ажилтныг захирлын тушаалаар томилж ирүүлэх.
ТШЗ 17.3	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “Үгүй”
ТШЗ 17.5	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “Үгүй”
ТШЗ 18.4	Зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ: “Шаардахгүй”
ТШЗ 18.6	Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардахгүй”
ТШЗ 19.1	Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм” Үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацаа; Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2024, 2025 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, бусад шаардлагатай мэдээллийг авна. Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: 1. Борлуулалтын орлогын хэмжээ: 2024, 2025 он тус бүрийн борлуулалтын орлогын хэмжээ батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна. Тендерт оролцогчийн борлуулалтын орлогын мэдээллийг сангийн яамны санхүүгийн тайлангын www.e-balance.mof.gov.mn мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана. 2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд: ✓ Байгууллагын харилцагч банкна дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа дансны хуулгыг харилцагч банкаар баталгаажуулж дансны үлдэгдлийг баталгааны хамт ирүүлсэн байна. ✓ Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий судлагдсан шугамын зээлийн тодорхойлолт ирүүлнэ. /Банкны судлан үзэж, зээл олгох боломжтой гэсэн утга бүхий мэдэгдлийг үнэлгээнд харгалзахгүй/ ✓ Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй байна. (Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй гэдгийг нотлохын тулд “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)
ТШЗ 20.1	Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана” Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”

	Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих жилийн тоо 2024, 2025 он тус бүр доод тал нь нэг удаа, батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй бараа нийлүүлсэн байх. - Ижил төстэй ажил гүйцэтгэснийг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд: - Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох ажил гүйцэтгэх гэрээний хуулбар, - Эрх бүхий байгууллагын хүлээн авсан комиссын дүгнэлт эсхүл акт - Урьд өмнөх байгуулсан гэрээ болон гэрээний хэрэгжилтийг нуун дарагдуулж болохгүйг анхаарна уу. Ажил гүйцэтгэсэн гэрээ, улсын комисс хүлээн авсан дүгнэлт, хавсралтуудын хуулбар, Захиалагч байгууллагын тодорхойлолтыг тус тус ирүүлнэ. Аль нэг баримтыг ирүүлээгүй бол тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.
ТШЗ 21.3	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 21.4	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “Туйм” <i>Incoterms 2020, DDP, бараа хүргэх газар: Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын Тамгын газар</i>
ТШЗ 22.2	Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар, эсхүл захиалагч Монголбанкнаас зөвшөөрөл авснаар тендерийн валютыг ТШЗ-ны 22.1-д зааснаас өөрөөр заах бол: “төгрөг”
Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ, ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ, ТЕНДЕР НЭЭХ	
ТШЗ 24.5.	Оролцогчдод ил болгох нэмэлт баримт бичгийн жагсаалт: Оролцогчдод ил болгох нэмэлт баримт бичгийн жагсаалт: - Хуулийн 7 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлага хангасныг нотлох баримт бичиг. - Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл Хуульд заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл байгаа бол хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл.
ТШЗ 25.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: [2026.04.10] Цаг: [11 цаг 00] минутанд
ТШЗ 26.3	Үнийн санал дуудах ажиллагаа эхлэх, үргэлжлэх хугацаа: Огноо: [2026 оны 04 дүгээр сарын 10 өдөр] Цаг: [14:00] минутанд
ТШЗ 27.1	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2026 оны 04 сарын 10 өдөр Цаг: [12:00] минутанд Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <i>Баянхонгор аймгийн Жинст сумын Засаг даргын Тамгын газар 2-р давхар 205 тоот өрөө</i>
Д.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 28.3	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Санамж

Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Зураг, төсөл

[Шаардлагатай бол барааны үндсэн хэмжээснүүдийг харуулсан (урт, өргөн, өндөр, голч г.м.) зургийг хавсаргана.]

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.]

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **[2026 оны 04 дүгээр сарын 03 өдөр]**
Тендер шалгаруулалтын төрөл: **Бараа**
Тендер шалгаруулалтын нэр: **[Үндэсний бөхийн дэвжээ худалдан авах]**
Тендер шалгаруулалтын дугаар: **[БХАЖИСЗДТГ/20260202006]**
Нийт төсөвт өртөг: **[40,000,000 /Дөчин сая төгрөг/]**
Тендер шалгаруулалтын арга: **Харьцуулалт**

1. **[Жинст сумын Засаг даргын Тамгын газар]** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **[“Үгүй”]**
3. Үнийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: **[үнийн санал дуудах ажиллагаа хүчин төгөлдөр байхад шаардлагатай оролцогчийн тоог бичих]**
4. Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: **[хэрхэн яаж бүртгүүлэх талаар дэлгэнгүй мэдээллийг бичнэ үү]**
5. Үнийн санал дуудах ажиллагааг **[2026.04.10 12:00]**–т эхлүүлж, **[хоёроос доошгүй цаг байхаар заана]** хугацаанд зохион байгуулна.
6. Тендерийг **[2026.04.10 11:00]**–аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **[2026.04.10]-ны өдрийн, [12:00]-т** нээнэ.
7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **[“Зөвшөөрөхгүй”]**
8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **[“Эрхгүй”]**
9. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

[Жинст сумын Засаг даргын Тамгын газар 91112879 96123455]



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**

1-114 дүгээр байр, Таван элс, Бодь 5 дугаар баг, Жинст
сум, Баянхонгор аймаг, 64073 Утас: 91118506
Цахим шуудан: info@jinst.bkh.gov.mn

“АРВИН ХОНГОР ХХК”-Д

2026.04.23 № 10/33

танай _____-ны № _____-т

Гэрээ байгуулах эрх олгох тухай

“Үндэсний бөхийн дэвжээ худалдан авах” бараа нийлүүлэх ажлын сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны шийдвэр, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 28 дүгээр зүйлийн 28.1.1 дэх заалтыг үндэслэн МЭДЭГДЭХ нь:

1. “АРВИН ХОНГОР ХХК” нь тус ажлыг 40,000,000 (Дөчин сая) төгрөгөөр хийж гүйцэтгэхээр үнийн санал холбогдох материалыг ирүүлсэн нь үнэлгээний хорооны гишүүдийн санал, тендерт оролцохоор ирүүлсэн материалыг нэг бүрчлэн үнэлсэн үнэлгээний дүнгүүдийг үндэслэн энэхүү тендерт “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж тус аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах эрх олгож байна.

2. Гэрээг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдснээс хойш ажлын 6-аас доошгүй өдрийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж байгуулна уу.

ДАРГА

Б.АЛТАНХУЯГ

642504058

